Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газрын хариуцсан нутаг дэвсгэрт 2023 оны 9-р сард 145918 зөрчлийг илрүүлж өмнөх онтой харьцуулахад 8650 (5.9%)-аар буурсан, 1811 иргэнийг баривчлуулж ажилласан нь 213 (11.8%)-аар буурсан, гэр бүлийн хүчирхийллийн улмаас 1136 иргэнийг шүүхээр баривчлуулсан байна.

Гэмт хэргийн улмаас 939 хүн гэмтэж осолдон, 83 хүн нас барж, төр ард иргэдэд 36636.6 сая төгрөгийн хохирол учруулсны 17790.0 (48.6%) сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

ХҮСНЭГТ 13.БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, хороогоор, төрлөөр

| Хороод     | Нийт дүн | Хүнийг алах /10.1/ | Хүнийг амиа хорлох нөхцөлд байдалд хүргэх /10.4/ | Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг /11.1-11.7/ | Хүчиндэх /12.1/ | Хулгайлах /17.1/ | Дээрэмдэх /17.2/ | Залилан мэхлэх /17.3/ | Малын хулгай /17.12/ | Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг /27.1-27.11/ | Бусад |
|------------|----------|--------------------|--------------------------------------------------|---------------------------------------------------------|-----------------|------------------|------------------|-----------------------|----------------------|--------------------------------------------------------------------------------------|-------|
| 1-р хороо  | 194      | -                  | 1                                                | 20                                                      | 2               | 22               | 2                | 128                   | -                    | 2                                                                                    | 17    |
| 2-р хороо  | 151      | 2                  | 1                                                | 38                                                      | 7               | 29               | 3                | 48                    | -                    | -                                                                                    | 23    |
| 3-р хороо  | 184      | 1                  | 1                                                | 26                                                      | -               | 50               | 7                | 69                    | -                    | 4                                                                                    | 26    |
| 4-р хороо  | 145      | -                  | 1                                                | 27                                                      | -               | 30               | 3                | 61                    | -                    | 3                                                                                    | 20    |
| 5-р хороо  | 106      | 1                  | 1                                                | 30                                                      | 3               | 17               | -                | 15                    | -                    | 7                                                                                    | 32    |
| 6-р хороо  | 170      | 1                  | 2                                                | 26                                                      | -               | 21               | -                | 97                    | -                    | 4                                                                                    | 19    |
| 7-р хороо  | 209      | 1                  | 2                                                | 52                                                      | -               | 32               | 8                | 88                    | -                    | 3                                                                                    | 23    |
| 8-р хороо  | 206      | 1                  | 5                                                | 44                                                      | 2               | 28               | 2                | 96                    | -                    | 2                                                                                    | 26    |
| 9-р хороо  | 89       | 1                  | -                                                | 20                                                      | 1               | 8                | 3                | 50                    | -                    | 1                                                                                    | 5     |
| 10-р хороо | 66       | -                  | 3                                                | 21                                                      | 1               | 13               | -                | 18                    | -                    | 1                                                                                    | 9     |
| 11-р хороо | 144      | -                  | 5                                                | 23                                                      | 2               | 31               | -                | 54                    | -                    | 13                                                                                   | 16    |
| 12-р хороо | 72       | -                  | 3                                                | 22                                                      | -               | 18               | -                | 14                    | -                    | 2                                                                                    | 13    |
| 13-р хороо | 106      | -                  | 2                                                | 8                                                       | 1               | 16               | 1                | 50                    | -                    | 5                                                                                    | 23    |
| 14-р хороо | 216      | 2                  | 2                                                | 40                                                      | 2               | 34               | 2                | 73                    | -                    | 14                                                                                   | 46    |
| 15-р хороо | 108      | -                  | 2                                                | 14                                                      | 1               | 19               | -                | 52                    | -                    | -                                                                                    | 20    |
| 16-р хороо | 183      | 2                  | 3                                                | 32                                                      | 2               | 32               | 1                | 76                    | -                    | 6                                                                                    | 29    |
| 17-р хороо | 72       | -                  | 2                                                | 20                                                      | 2               | 16               | 1                | 23                    | -                    | 2                                                                                    | 6     |
| 18-р хороо | 442      | -                  | 1                                                | 10                                                      | 2               | 15               | 2                | 393                   | -                    | 2                                                                                    | 17    |
| 19-р хороо | 88       | 2                  | 1                                                | 38                                                      | 1               | 12               | 1                | 19                    | -                    | 1                                                                                    | 13    |
| 20-р хороо | 79       | 2                  | 5                                                | 21                                                      | 2               | 20               | -                | 16                    | -                    | 1                                                                                    | 11    |
| 21-р хороо | 92       | 1                  | 3                                                | 34                                                      | 2               | 14               | 1                | 24                    | 2                    | 4                                                                                    | 7     |
| 22-р хороо | 134      | -                  | 3                                                | 23                                                      | 1               | 18               | -                | 73                    | -                    | 2                                                                                    | 14    |
| 23-р хороо | 78       | -                  | 4                                                | 32                                                      | -               | 13               | 1                | 23                    | -                    | 1                                                                                    | 4     |
| 24-р хороо | 42       | -                  | -                                                | 9                                                       | -               | 6                | 1                | 24                    | -                    | -                                                                                    | 2     |
| 25-р хороо | 81       | -                  | 2                                                | 18                                                      | 1               | 8                | -                | 29                    | -                    | 3                                                                                    | 20    |
| 26-р хороо | 169      | -                  | -                                                | 18                                                      | 2               | 32               | -                | 61                    | -                    | 13                                                                                   | 43    |
| 27-р хороо | 99       | -                  | 1                                                | 25                                                      | 1               | 17               | -                | 46                    | -                    | 3                                                                                    | 6     |

|            |      |    |    |     |    |     |    |      |   |     |     |
|------------|------|----|----|-----|----|-----|----|------|---|-----|-----|
| 28-р хороо | 65   | -  | 6  | 13  | 3  | 13  | -  | 23   | - | -   | 7   |
| 29-р хороо | 53   | -  | -  | 14  | 2  | 18  | 1  | 11   | - | 2   | 5   |
| 30-р хороо | 93   | -  | 2  | 16  | 3  | 16  | -  | 42   | - | 1   | 13  |
| 31-р хороо | 41   | -  | 4  | 5   | -  | 7   | 1  | 15   | - | 1   | 8   |
| 32-р хороо | 45   | -  | 1  | 13  | -  | 6   | -  | 21   | - | 1   | 3   |
| 33-р хороо | 18   | -  | 1  | 5   | -  | 4   | -  | 6    | - | 1   | 1   |
| 34-р хороо | 18   | -  | -  | 8   | -  | 8   | -  | 1    | - | -   | 1   |
| 35-р хороо | 15   | -  | -  | 5   | -  | 5   | -  | 4    | 1 | -   | -   |
| 36-р хороо | 62   | 1  | -  | 12  | 1  | 12  | -  | 21   | - | -   | 15  |
| 37-р хороо | 21   | -  | 1  | 8   | 1  | 3   | 1  | 3    | - | -   | 4   |
| 38-р хороо | 42   | 1  | 1  | 12  | 1  | 13  | 1  | 11   | - | -   | 2   |
| 39-р хороо | 34   | -  | 1  | 9   | 1  | 15  | -  | 3    | - | 2   | 3   |
| 40-р хороо | 61   | -  | 3  | 19  | 2  | 8   | -  | 16   | - | -   | 13  |
| 41-р хороо | 54   | -  | -  | 17  | 3  | 5   | 1  | 17   | - | 1   | 10  |
| 42-р хороо | 100  | -  | 1  | 19  | 1  | 33  | 1  | 29   | - | -   | 16  |
| 43-р хороо | 46   | -  | 2  | 13  | -  | 7   | -  | 19   | - | -   | 5   |
| Нийт дүн   | 4494 | 19 | 79 | 879 | 56 | 744 | 45 | 1963 | 3 | 108 | 596 |

#### Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000-аар үржүүлж тооцно.

Хохирогч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохирол тооцно.


Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.






# БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, 2023 оны 9 дүгээр сард, тэрбум төгрөг

ᠪᠠᠶ᠋ᠠᠨᠵᠢᠷᠬᠡ



## Баянзүрх дүүргийн нэгдсэн төсвийн орлого, зарлагын бүтэц






## ДҮҮРГИЙН ТӨСӨВ

2023 оны 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр дүүргийн төсвийн орлого 151.5 тэрбум төгрөг, төсвийн зарлага 94.8 тэрбум төгрөг болж, төсвийн тэнцэл 56.7 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

ХҮСНЭГТ 14. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн 9 сард


| Үзүүлэлт                       | 2020       | 2021      | 2022      | 2023      |
|--------------------------------|------------|-----------|-----------|-----------|
|                                | сая төгрөг |           |           |           |
| Төсвийн орлого                 | 106 817.0  | 123 603.7 | 107 267.4 | 151 532.5 |
| Төсвийн зарлага                | 96 315.5   | 99 319.8  | 59 956.5  | 94 849.3  |
| Төсвийн орлого, зарлагын зөрүү | 10 501.5   | 24 283.9  | 47 310.9  | 56 683.2  |

ЗУРАГ 6. ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, САЯ ТӨГРӨГ



**Төсвийн орлого:** 2023 оны 9 сарын төсвийн гүйцэтгэлийн урьдчилсан мэдээгээр нийт дүүргийн төсвийн орлогын 148.2 тэрбум төгрөгийг (96.7%) татварын орлого, 1.6 тэрбум төгрөгийг (1.1%) татварын бус орлого, 3.2 тэрбум төгрөгийг (2.2%) орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлого тус тус эзэлж байна. Төсвийн орлогын гүйцэтгэл төлөвлөгөөнөөс 32.2 тэрбум төгрөгөөр дутуу бүрдсэн байна. Үүнд татварын орлого 32.3 тэрбум төгрөгөөр (18.1%) дутуу бүрдсэн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

ЗУРАГ 7. ТӨСВИЙН ОРЛОГО, сая төгрөг



ХҮСНЭГТ 15. ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ, сая төгрөг

| Үзүүлэлт                                    | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | ТБ%   | Зөрүү     |
|---------------------------------------------|------------|-----------|-------|-----------|
| Нийт орлогын дүн                            | 183 767.5  | 151 532.5 | 82.5  | -32 235.0 |
| Тусламжийн орлого                           | 3 557.5    | 3 278.8   | 92.2  | -278.7    |
| Тусгай зориулалттай шилжүүлгээс             | 0          | 0         | 0     | 0         |
| Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан           | 3 557.5    | 3 278.8   | 92.2  | -278.8    |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих <sup>1</sup> | 180 210.0  | 148 253.7 | 82.3  | -31 956.3 |
| Татварын орлого                             | 178 986.4  | 146 598.2 | 81.9  | -32 388.2 |
| Татварын бус орлого <sup>2</sup>            | 1 223.6    | 1 655.5   | 135.3 | 431.9     |

ХҮСНЭГТ 16. ТАТВАРЫН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, сая төгрөг

| Үзүүлэлт                                                                                         | 2023 он    |                      |           |            |
|--------------------------------------------------------------------------------------------------|------------|----------------------|-----------|------------|
|                                                                                                  | Нийт төсөв | Өссөн дүн ( IX сард) |           |            |
|                                                                                                  |            | Төлөвлөгөө           | Гүйцэтгэл | Хувийн жин |
| Татварын орлого                                                                                  | 254 785.6  | 178 986.4            | 146 598.2 | 81.9       |
| Орлогын албан татвар                                                                             | 187 849.9  | 128 467.7            | 121 678.9 | 94.7       |
| Хувь хүний орлогын албан татвар                                                                  | 187 849.9  | 128 467.7            | 121 678.9 | 94.7       |
| Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого | 135 080.1  | 85 835.8             | 80 939.3  | 94.3       |
| Үйл ажиллагааны орлого                                                                           | 5 100.0    | 3 820.0              | 4 606.3   | 120.6      |
| Хөрөнгийн орлого                                                                                 | 11 719.8   | 9 499.6              | 7 778.0   | 81.9       |
| Хөрөнгө борлуулсны орлого                                                                        | 16 450.0   | 11 988.0             | 13 154.4  | 109.7      |
| Шууд бус орлого                                                                                  | 19 500.0   | 17 324.3             | 15 200.8  | 87.7       |
| Хөрөнгийн албан татвар                                                                           | 35 085.7   | 24 704.5             | 8 107.6   | 32.8       |
| Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар                                                              | 35 000.7   | 24 644.5             | 8 058.2   | 32.7       |
| Бууны албан татвар                                                                               | 85.0       | 60.0                 | 48.5      | 80.8       |
| Малд ногдуулах албан татвар                                                                      | -          | -                    | -         | -          |
| Бусад татвар, төлбөр, хураамж                                                                    | 31 850.0   | 25 814.2             | 16 811.8  | 65.1       |
| Улсын тэмдэгтийн хураамж                                                                         | 6 000.0    | 4 300.0              | 3 337.0   | 77.6       |
| Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр                                                | -          | -                    | 190.6     | -          |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамж                                                                | 5 200.0    | 3 870.0              | 3 864.4   | 99.9       |
| Газрын төлбөр                                                                                    | 20 500.0   | 17 529.0             | 9 419.8   | 53.7       |
| Байгалийн нөөц ашигласны төлбөр                                                                  | 150.0      | 115.2                | -         | -          |

**Төсвийн зарлага:** 2023 оны 9 сарын урьдчилсан гүйцэтгэлийн мэдээгээр дүүргийн төсөвт байгууллагуудын төлөвлөсөн үйл ажиллагааны зардлын 46.2 хувийг (94.8 тэрбум төгрөг) санхүүжүүлжээ. Өөрөөр хэлбэл, төсөвт байгууллагууд үйл ажиллагааны нийт зардлын 53.8 хувийг (110.3 тэрбум төгрөг) төлөвлөсөн хугацаандаа зарцуулаагүй байна.

<sup>1</sup> Орон нутгийн төсвөөс санхүүжих дүнд урьд оны үлдэгдлээс санхүүжих дүн ороогүй.

<sup>2</sup> Татварын бус орлогод нийтлэг татварын бус орлого буюу торгуулийн орлого, төсөвт байгууллагын өөрийн орлогыг /үндсэн, туслах/ хамааруулсан.


ХҮСНЭГТ 17.ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ, сая төгрөг

| Үзүүлэлт                                                | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | ТБ%  | Зөрүү      |
|---------------------------------------------------------|------------|-----------|------|------------|
| Нийт зардлын дүн                                        | 205 146.7  | 94 849.3  | 46.2 | -110 297.4 |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил                      | 14 271.9   | 11 440.5  | 80.2 | -2 831.4   |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл          | 1 901.3    | 1 646.7   | 86.6 | -254.6     |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал               | 10 145.4   | 7 962.1   | 78.5 | -2 183.3   |
| Хангамж бараа материалын зардал                         | 10 374.2   | 9 988.7   | 96.3 | -385.5     |
| Нормативт зардал                                        | 25.9       | 12.2      | 47.1 | -13.7      |
| Эд, хогшил урсгал засварын зардал                       | 4 551.8    | 3 614.5   | 79.4 | -937.3     |
| Томилолт зочны зардал                                   | 405.0      | 189.9     | 46.9 | -215.1     |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж | 18 024.4   | 12 726.1  | 70.6 | -5 298.3   |
| Бараа үйлчилгээний бусад зардал                         | 5 863.2    | 2 762.9   | 47.1 | -3 100.3   |
| Татаас                                                  | -          | -         | -    | -          |
| Урсгал шилжүүлэг                                        | 102 156.6  | 3 277.2   | 32.1 | -69 384.6  |
| Хөрөнгийн зардал                                        | 37 427.1   | 11 733.7  | 31.4 | -25 693.4  |

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн сарын мэдээ

Төсвийн зарлагыг бүтцээр нь авч үзвэл 12.1 хувийг цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, 1.7 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалын санд төлөх шимтгэл, 8.4 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 10.5 хувийг хангамж бараа материалын зардал, 13.4 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж, 34.6 хувийг урсгал шилжүүлэг, 19.3 хувийг бусад зардлууд тус тус эзэлж байна.

ЗУРАГ 8.ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО, ЗАРЛАГА, сая төгрөг



Ойлголт, тодорхойлолт

Төсвийн орлого: Тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн орлого: Татварын болон татварын бус орлогоос бүрдэнэ.

Орон нутгийн төсөв: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж, зарцуулах төсөв юм.

Татварын орлого: Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн зарлагын ангилал: Урсгал зардал, хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл гэж ангилна.


Урсгал зардал: Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн тэнцэл: Тэнцвэржүүлсэн орлогоос нийт зарлага, цэвэр зээлийг хасаж тодорхойлно.



## ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, бүлгээр, хувиар, 2023 оны 9 дүгээр сард

Улаанбаатар, 2023 оны 9 сард





## ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ


2023 оны 9 дүгээр сард хэрэглээний үнийн индекс 2022 оны мөн үетэй харьцуулахад 10.2 хувиар өссөн, 2022 оны эцэстэй харьцуулахад 7.3 хувиар өссөн ба өмнөх сартай харьцуулахад 0.1 хувиар буурсан байна.

### ХҮСНЭГТ 18. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, барааны бүлгээр


| Бараа, үйлчилгээний бүлгийн нэр            | <u>2023 IX</u><br>2022 IX | <u>2023 IX</u><br>2022 XII | <u>2023 IX</u><br>2023 VIII |
|--------------------------------------------|---------------------------|----------------------------|-----------------------------|
| <b>Ерөнхий индекс</b>                      | <b>110.2</b>              | <b>107.3</b>               | <b>99.9</b>                 |
| Хүнсний бараа, ундаа ус                    | 116.8                     | 111.6                      | 98.7                        |
| Согтууруулах ундаа, тамхи                  | 105.1                     | 102.2                      | 100.0                       |
| Хувцас, гутал, бөс бараа                   | 108.6                     | 103.5                      | 100.2                       |
| Орон сууц, ус, түлш, цахилгаан             | 104.9                     | 103.0                      | 100.0                       |
| Гэр ахуйн бараа, тавилга                   | 107.2                     | 104.7                      | 99.8                        |
| Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ              | 108.4                     | 107.4                      | 101.1                       |
| Тээвэр                                     | 100.2                     | 99.6                       | 100.0                       |
| Холбооны үйлчилгээ                         | 101.0                     | 99.8                       | 99.5                        |
| Амралт чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ | 105.5                     | 103.4                      | 99.7                        |
| Боловсрол                                  | 121.2                     | 121.2                      | 100.0                       |
| Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр    | 119.0                     | 117.5                      | 101.5                       |
| Бусад бараа, үйлчилгээ                     | 102.8                     | 102.8                      | 100.0                       |

Хэрэглээний үнийн индекс 2023 оны 9 дүгээр сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.2 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 16.8 хувь, согтууруулах ундаа, тамхины үнэ 5.1 хувь, Хувцас, гутал, бөс барааны үнэ 8.6 хувь, гэр ахуйн бараа, тавилгын үнэ 7.2 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 8.4 хувь, Тээврийн үйлчилгээний үнэ 0.2 хувь, Холбооны үйлчилгээний үнэ 1.0 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын барааны үнэ 5.5 хувь, боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ 21.2 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үнэ 19.0 хувь, бусад бараа үйлчилгээ 2.8 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

### ЗУРАГ 9. ХҮНСНИЙ НОГООНЫ ДУНДАЖ ҮНЭ, төрлөөр, 2022, 2023 оны IX сард



ЗУРАГ 10. МАХНЫ ҮНЭ, төрлөөр, төгрөгөөр



ХҮСНЭГТ 19. ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ ТҮЛШ, шатахууны үнэ

| Үзүүлэлт                     | 2021 IX | 2022 IX | 2023 IX |
|------------------------------|---------|---------|---------|
|                              | төгрөг  |         |         |
| <b>Түлш:</b>                 |         |         |         |
| Хар мод                      | 5 000   | 6 500   | 6 000   |
| Нарс                         | 6 000   | 6 000   | 6 500   |
| Боловсруулсан нүүрс (шуудай) | 3 750   | 3 750   | 3 750   |
| <b>Шатахуун:</b>             |         |         |         |
| АИ-95                        | 2 650   | 3 910   | 3 710   |
| АИ-76, 80                    | 2 000   | 2 370   | 2 370   |
| АИ-92, 93                    | 2 050   | 2 390   | 2 390   |
| Дизельтүлш                   | 2 490   | 3 730   | 3 490   |
| Газ                          | 1 650   | 1 790   | 1 790   |

Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 62 дугаар тогтоол ТҮҮХИЙ НҮҮРС ХЭРЭГЛЭХИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ хуулийн дагуу 5 дугаар сарын 15-ны өдрөөс нүүрс борлуулахыг хориглосон.



ХҮСНЭГТ 20. ХҮНСНИЙ ӨРГӨН ХЭРЭГЛЭЭНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНЭ, оноор

| Нэр, төрөл                                 | Хэмжих нэгж | 2019 IX | 2020 IX | 2021 IX | 2022 IX | 2023 IX |
|--------------------------------------------|-------------|---------|---------|---------|---------|---------|
|                                            |             | Төгрөг  |         |         |         |         |
| Гурил, дээд зэрэг, “Алтан тариа”ХК         | кг          | 1 438   | 1 456   | 1 714   | 1 936   | 2 689   |
| Гурил, 1-р зэрэг, “Алтан тариа” ХК, задгай | кг          | 1 094   | 1 160   | 1 391   | 1 574   | 2 400   |
| Гурил, 2-р зэрэг, “Алтан тариа” ХК         | кг          | 862     | 890     | 971     | 1 209   | 1 589   |
| Талх, “Атар”, “Талх чихэр                  | кг          | 1 272   | 1 274   | 1 473   | 1 734   | 2 465   |
| Цагаан будаа, кг, задгай                   | кг          | 3 610   | 3 840   | 3 792   | 4 495   | 4 635   |
| Шар будаа                                  | кг          | 2 315   | 2 283   | 2 347   | 2 841   | 3 294   |
| Хонины мах                                 | кг          | 8 988   | 9 240   | 11 374  | 11 772  | 14 026  |
| Үхрийн мах                                 | кг          | 11 546  | 11 576  | 14 632  | 14 440  | 16 314  |
| Адууны мах                                 | кг          | 9 400   | 10 750  | 10 000  | 10 247  | 11 247  |
| Сүү, задгай                                | литр        | 1 720   | 1 840   | 1 911   | 2 800   | 2 000   |
| Сүү, савласан, “Элекстер”                  | 0.5 литр    | 1 130   | 1 174   | 1 344   | 1 830   | 2 259   |
| Төмс, дотоод                               | кг          | 1 130   | 576     | 804     | 1 204   | 1 539   |
| Лууван, дотоод                             | кг          | 1 516   | 996     | 2 402   | 2 184   | 2 315   |
| Хүрэн манжин, дотоод                       | кг          | 1 794   | 1 030   | 2 065   | 3 230   | 2 893   |
| Байцаа, дотоод                             | кг          | 2 072   | 666     | 1 544   | 1 947   | 2 447   |
| Сонгино, хятад                             | кг          | 2 040   | 1 514   | 2 093   | 4 475   | 2 857   |
| Элсэн чихэр, ОХУ                           | кг          | 3 146   | 3 072   | 2 931   | 3 732   | 4 734   |
| Өндөг                                      | ширхэг      | 365     | 333     | 389     | 460     | 530     |

### Ойлголт, тодорхойлолт

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин: Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

Хэрэглээний үнийн индекс: Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

$$I_{ct}^L = \sum \left( \frac{P_{it}}{P_{it-1}} \right) \left( \frac{P_{it-1}}{P_{it-2}} \right) \dots \left( \frac{P_{i2}}{P_{i1}} \right) \left( \frac{P_{i1}}{P_{i0}} \right) \frac{P_{i0} Q_{i0}}{\sum P_{i0} Q_{i0}}$$

$I_{ct}^L$  – тайлант үеийн хувиргасан Ласпейрсийн индекс (t)

t – тайлант үе

i – бараа, үйлчилгээ

o – суурь үе

$P_i^t$  – i барааны тайлант үеийн үнэ

$P_i^o$  – i барааны суурь үеийн үнэ

$Q_i^o$  – i барааны суурь үеийн жин



## АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, 2023 оны 9 дүгээр сард


Уул уурхай, олборлолт, тэрбум төгрөг

Боловсруулах үйлдвэрлэл, тэрбум төгрөг


Цахилгаан хий, уур, агааржуулалт, тэрбум төгрөг

Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал, зайлуулахболон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа, тэрбум төгрөг



Уул уурхай, олборлолт, тэрбум төгрөг




Боловсруулах үйлдвэрлэл, тэрбум төгрөг



Цахилгаан хий, уур, агааржуулалт, тэрбум төгрөг



Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал, зайлуулахболон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа, тэрбум төгрөг





## АЖ ҮЙЛДВЭР

Дүүргийн аж үйлдвэрийн салбар нь 2023 оны эхний 9 сард 1617.5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 1907.3 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал үйлдвэрлэлт 190.2 тэрбум төгрөгөөр (13.3%), борлуулалт 203.2 тэрбум төгрөгөөр (11.9%)-иар тус тус

өссөн үзүүлэлттэй байна.

Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 965.9 тэрбум төгрөгийг (59.7%) уул уурхайн салбарын газрын түүхий тос болон хайлуур жонш, хайлуур жоншны баяжмал, төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмал, алт, элс, хайрга, шороо олборлолт, 453.2 тэрбум төгрөгийг (28.0%) хүнс ундаа, 112.3 тэрбум төгрөгийг (6.9%) хувцас, гутал, нэхмэл, ноос, ноолуур боловсруулах болон бусад боловсруулах үйлдвэрлэлт, 1.3 тэрбум төгрөгийг (0.1%) цахилгаан, хий, уур, агааржуулалт үлдсэн 84.7 тэрбум төгрөгийг (5.2%) бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа тус тус эзэлж байна.

ЗУРАГ 11. АЖ ҮЙЛДВЭРИЙН 2022-2023 ОНЫ ҮЙЛДВЭРЛЭЛТ, БОРЛУУЛАЛТ, тэрбум төгрөг



Боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн өсөлтөд хүнсний үйлдвэрлэлт, нэхмэлийн үйлдвэрлэлт, үндсэн эмийн бүтээгдэхүүн болон эмийн бэлдмэлийн үйлдвэрлэл, төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл, арьс арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад үйлдвэрлэлт нөлөө үзүүлсэн байна.

ХҮСНЭГТ 21.АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, салбараар, оны үнээр

| Салбар                     |                                                                                         | 2022                                                                                                                                               | 2023      | өсөлт,<br>бууралт |          |
|----------------------------|-----------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------|-------------------|----------|
|                            |                                                                                         | сая төгрөг                                                                                                                                         |           |                   |          |
| Нийт                       |                                                                                         | 1059447.8                                                                                                                                          | 1617481.1 | 558033.3          |          |
| Уул уурхай<br>олборлолт    | Дэд салбарын нийт дүн                                                                   | 513988.2                                                                                                                                           | 965965.7  | 488 983.9         |          |
|                            | Газрын түүхий тос, байгалийн хий олборлолт                                              | 291 671.0                                                                                                                                          | 785 178.9 | 493 507.9         |          |
|                            | Металлын хүдэр олборлолт                                                                | 51 486.2                                                                                                                                           | 55 092.8  | 3 606.5           |          |
|                            | Бусад ашигт малтмал олборлолт                                                           | Чулуу, элс, шороо олборлолт                                                                                                                        | 4 932.9   | 2 246.6           | -2 686.3 |
|                            |                                                                                         | Дээрх ангилалд ороогүй бусад ашигт малтмалын олборлолт                                                                                             | 9 093.1   | 3 648.8           | -5 444.3 |
|                            |                                                                                         |                                                                                                                                                    |           |                   |          |
| Боловсруулах<br>үйлдвэрлэл | Дэд салбарын нийт дүн                                                                   | 409 056.4                                                                                                                                          | 505 333.5 | 96 277.1          |          |
|                            | Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл                                                       | Мах боловсруулах, консервлох                                                                                                                       | 61 159.5  | 85 669.7          | 24 510.2 |
|                            |                                                                                         | Жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалт                                                                                            | 6 460.6   | 9 888.0           | 3 427.4  |
|                            |                                                                                         | Сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл                                                                                                                       | 3 911.9   | 13 858.3          | 9 946.4  |
